



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. БНАСАУ-ЫН Элчин Сайдын Яамны аюулгүй байдлыг хангах хүрээнд хашааг битүүлэх болон “Улсын үзлэг зохион байгуулах тухай” Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 681 дүгээр тогтоолын 2дугаар хавсралтаар баталсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний “...хөрөнгө оруулалт 488,802,597.0 төгрөг” гэснийг “...хөрөнгө оруулалт 586,647,072.08 төгрөг” гэж өөрчилсүгэй.

2. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт орсондой холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 681 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний их засварын ажилд хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал Ё.Нямжавт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын ~~28~~ ны өдрийн
258.. дугаар тогтоолын хавсралт

**“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭГДЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Төсөвт өртөг
7	“ДБҮЭГ”ын 14 дүгээр байрны архивын их засвар	1	40,452,655.0	40,452,655.0
8	“ДБҮЭГ”ын 9-р байрны гадна талбайн хашаа	1	57,391,820.08	57,391,820.08
	НИЙТ ДҮН			97,844,475.08